

**“ДУЛААН ЦЭВЭР БОХИРЫН ШУГАМЫН ӨРГӨТГӨЛ” АЖЛЫН ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ**

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын дулаан, цэвэр, бохир усны шугам өргөтгөл угсралтын ажил:

А. Тус ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол улсын барилгын норм ба дүрэм, олон улсын стандартууд, эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, холбогдох дүрэм, журам, нормыг мөрдөж ажиллана.

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн үзүүлэлтийг гаргаж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйг хангах, ажлын баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Г.Барилга байгууламжийн ажлыг төсвийг тооцохдоо “Барилгын төсөв зохиох дүрэм” БНБД 81-95-12\* (2020)-д заасны дагуу тоног төхөөрөмжийн үнийг материалын үнэд оруулахгүй тусд нь тооцож ирүүлнэ.

Д. Тендерийн үнийн саналд дулаан цэвэр бохирын шугамын зураг төсвийн үнэ 5000000 төгрөг, мөн зохиогчийн хяналтын зардлыг техник хяналтын зардлын 50 хувиар тооцож үнийн саналд тус тус тусгаж ирүүлэх.

**1. Дулаан, цэвэр, бохир усны шугамын өргөтгөлийн ажил**

Дулаан, цэвэр, бохир усны шугамын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэхдээ Гадна дулаан хангамж БНБД 41-02-13, Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНБД 41-04-13, Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16, Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ барилга байгууламж БНБД 40-04-16-г тус тус баримтлана.

Хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцлийн дагуу дулаан, цэвэр, бохир усны шугамыг өргөтгөн шинэчилж, шугамын диаметрийг ажлын зурагт тусгасны дагуу ган хоолойг сонгон угсарч суурилуулна.

Яндан хоолойн агшилт, суналтыг зөөлөвч болон өөрийн эргэлтийг ашиглан нөхнө.

Яндан хоолойн угсралтын үед гадна хог шороо, бохирдлоос цэвэрлэж, зэврэлтээс хамгаалах түрхлэг түрхэн дулаалгыг хийж өгнө.

Яндан хоолойн дулаалгын материалыг пенопласт болон пенополиуратан материалаар сонгоно. Дулаалгын гадуур хамгаалах бүрхүүлийг хийж өгөх хэрэгтэй.

Дулааны шугамыг угсрахдаа угсралтын норм дүрмийн дагуу гүйцэтгэж зохих даралтаар шалгах хэрэгтэй.

Ус дамжуулах шугамын доод цэгт юүлэх, дээд цэгт хий авах хаалтыг угсрах хэрэгтэй.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Дулаан, цэвэр, бохир усны шугамын өргөтгөлийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, пасдорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторын шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторын сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилга байгууламжийн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
7. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Гүйцэтгэгч нь зуухны ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.
9. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч

эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

10. Монгол улсын “Барилгын тухай” хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-д /14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/ 14.6-д /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/ гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага **чанарын баталгаа** гаргаж өгнө.
11. Тендерийн төсвийг тэргүүлэх болон мэргэшсэн зэрэгтэй /эрхийн хугацаа дуусаагүй, тухайн ажилбарын хүрээнд хамаарах/ төсөвчнөөр гүйцэтгүүлнэ.
12. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, зохиогчийн хяналт, зураг төсвийн үнэ, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “IY” 81-95-12-г мөрдлөг болгоно.